



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/212

Бор-Өндөр сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий
нэгж талбарыг нэгтгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгох журам"-ын 8.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий нэгж талбарыг нэгтгэх хүсэлт гаргасан иргэний хүсэлтийг харгалзан үзэж, эзэмшлийн газрыг нэгдүгээр хавсралтад заасны дагуу нэгтгэсүгэй.


2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг захирамжаар зөвшөөрөгдөж, нэгтгэгдсэн газрын хэмжээгээр олгож, газар эзэмшүүлэх гэрээ байгуулахыг Газрын даамал /Т.Эрдэнэзаяа/-д даалгасугай.

3. Газар эзэмших гэрээний нөхцөл, зориулалтын дагуу газраа эзэмшин, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч /Ч.Энхбаяр/-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ



Сумын Засаг даргын 2024 оны 10 сарын 29 өдрийн А/212... тоот захирамжийн Нэгдүгээр хавсралт

Нэгтгэгдэж байгаа нэгж талбарын мэдээлэл

д/д	Газар эзэмшигч хуулийн этгээдийн нэр	регистр	Нэгтгэгдэж буй нэгж талбарын				Нэгтгэгдсэн нэгж талбарын газрын	
			байршил	нэгж талбарын дугаар	хэмжээ /мкв/	хэмжээ /мкв/	зориулалт	эзэмших хугацаа /жил/
1	Морьт Чойжилсүрэн Энхбаяр	СЦ68041212	1-р баг Бор-Өндөр, Худалдаа-1 гудамж, 103а	2322002390	72	352	2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний төв, цогцолбор	3
			1-р баг Бор-Өндөр, Худалдаа-1 гудамж, 103б	2322003845	100			
			1-р баг Бор-Өндөр, Худалдаа-1 гудамж, 103в	2322002333	100			
			1-р баг Бор-Өндөр, Худалдаа-1 гудамж, 103д	2322003219	80			